



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 114

Улаанбаатар хот

### Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дугээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу “Эксим” банкны хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлж бий болсон, нийт 52,887,086,839.70 (тавин хоёр тэрбум найман зуун наян долоон сая наян зургаан мянга найман зуун гучин есөн төгрөг далан мөнгө) төгрөгийн үнэ бүхий Үндэсний оношилгоо, эмчилгээний төвийн барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлэгт эзэмшиүүлж үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн захирал Б.Бямбадорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бурийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, хөрөнгөд бүртгэх, асуудлыг шийдвэрлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ  
132001271  
9-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
нийтийн одрийн  
2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн хавсралт  
11:45.....дугаар тогтоопын хавсралт

"ЭКСИМ" БАНКНЫ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН САНХУУЖИЛТ  
(МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ СОЛООНГОС УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН)-ЭР БАРИГДСАН,  
УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАТСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дун (төгрөг)	Улсын комиссын акт Огноо	Улсын комиссын акт Дугаар
1	Үндэсний оношлогоо, эмчилгээний төвийн барилга (НИЙСПЭЛИЙН БАЯНЗУРХ ДҮҮРГИЙН 3 ДУГААР ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЭЗЭМШЛИЙН ГАЗАР ДЭЭР)	Эмнэлэг Үйлчилгээний зориулалттай, онцгой төвөгшилтэй ангилалын, 2 давхар зоорьтой, циклотроны бичил үйлдвэртэй, 4 давхар, 103 ор, яаралтай туслаамжийн 9 ортой, тэнхлэгээрээ 85.8M*39.0 м барилга	52,887,086,839.70	2019.12.03	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 001
			52,887,086,839.70		(тавин хоёр тэрбум хоёр найман зуун наян долзоон сая наян зургаан мянга найман зуун гучин есөн төгрөг далан мөнгө)

НИЙТ ДҮН